



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№120 /334/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.07.05

Цаг үе, үйл явдал

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРООНООС МЭДЭЭЛЭЛ ХИЙЛЭЭ

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн баталсантай холбоотойгоор өнөөдөр Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооноос мэдээлэл хийлээ.

Үндэсний бөхийн салбар хорооны дарга П.Сайнзориг “Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлд зааснаар Улсын их баяр наадамд 10 жил тутам Их Монгол Улс байгуулагдсаны болон Ардын хувьсгалын тэгш ойг давхцуулан 16 насанд хүрсэн 1024 бөх, бусад баяр наадамд 512 бөх барилдахаар заасан. Харин Үндэсний бөх, хурдан морь, сурын болон шагайн харвааны цол, чимэг олгох тухайд бөх, сурын харваач допинг хэрэглэсэн нь допингийн шинжилгээгээр тогтоогдсон бол уг шинжилгээний хариу гарсан өдрөөс хойш гурван хоногийн дотор шинжилгээний хариу, батламжийг үндэслэн тухайн бөхийн улсын цолыг хураалгах саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид хүргүүлнэ. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч энэ зүйлийн саналыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор зарлиг гаргаж, тухайн бөхөд олгосон улсын цолыг хураахаар хуульд тусгасан” гэсэн юм.

Хурдан морины тухайд Монгол үүлдрийн морины санг бүрдүүлж дуустал дүрмээр зохицуулахаар болсон. Тус дүрэмд хурдан мориныг сэрвээний өндрөөр хэмжихээр заасан бөгөөд ингэхдээ телевиз болон цахим хуудсуудаар шууд дамжуулж, олон нийтэд нээлттэй байдлаар зохион байгуулахаар болсон талаар Хурдан



морины салбар хорооны дарга, Батлан хамгаалах яамны төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг мэдээллээ.

Хуульд баяр наадмын брэнд хөтөч, өнгө төрхийг шинээр баталсан. Үүнтэй уялдуулан баяр наадмын үеэр орон даяар нэг нэр нэршил, брэнд өнгө төрхтэй байх чиглэлийг хүргүүлж ажиллахыг Соёлын яаманд даалгасан. Энэхүү ажлын хүрээнд баяр наадмын брэнд

хөтөч, өнгө төрхийг албажуулан 21 аймаг, 9 дүүрэгт хүргээд байгаа талаар Урлаг соёлын арга хэмжээний салбар хорооноос мэдээлсэн юм.

Энэ үеэр Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойн баяр наадмын нээлт, хаалтын тасалбар болон автомашины зогсоолын зөвшөөрлийг 7 дугаар сарын 1-3-нд худалдаж дууссан бол худалдаа үйлчилгээ гаргах зөвшөөрлийг хүнсний аюулгүй байдлыг хангах үүднээс Ulaanbaatar.mn цахим хаягаар зөвхөн аж

ахуйн нэгж байгууллагын хүсэлтийг хүлээн авч, олгож буйг нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга И.Баатархүү мэдээлэв.

Мөн Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах бэлтгэл ажил 85 хувьтай байгаа бөгөөд төлөвлөгөөний дагуу хангагдаж байгаа талаар салбар хороодын дарга нар танилцуулсан юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 18	🌙 09


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 35	🌙 24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.155.00	3.159.0
EUR 🇪🇺	3.329.0	3.318.0
CNY 🇨🇳	473.00	475.00
RUB 🇷🇺	53.20	54.20
JPY 🇯🇵	23.35	23.55
KRW 🇰🇷	2.41	2.44

ЗУРХАЙ



2022.07.05 /МЯГМАР ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 6

ЗУНЫ ДУНД УЛААН МОРЬ САРЫН ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:

Өнгө зүс сайжирна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.00-20.54

Барилдлага:

Хүчин төгсөх

Шүтэн барилдлага:

Төрөхүй

Суудал: Хий

ГЕНЕРАЛЫН ГАВЬЯАТ ҮЙЛСИЙГ СУРТАЛЧЛАВ



“Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн ажилтны Нэгдсэн эвлэл” ТББ-аас хоёр дайнд оролцсон цэргийн улс төрийн ажилтан, хошууч генерал Чимидийн Данзангийн дурсгалыг мөнхжүүлэх ажлыг 2022 оны эхнээс төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж иржээ. Дайны талбарт болон энх цагийн бүтээн байгуулалтад нэр алдраа дуурьсаж явсан генералын түүхэн замналаар мэдээллийн 6 самбар бэлтгэж өнгөрсөн 3 дугаар сард “Монгол цэргийн өдөр”-ийн босгон дээр Монгол цэргийн музейд “Дурсамж уулзалт” зохион байгуулсан.

Энэ уулзалтын үеэр хошууч генерал Ч.Данзангийн байгуулсан гавьяаг төрсөн нутаг Сүхбаатар аймагт сурталчлах тухай яригдаж оролцсон хүмүүсийн талархлыг хүлээж байлаа. Энэ санаа бодит ажил хэрэг болж 6 дугаар сарын 27, 28-нд их жанжны нутагт эх орны цэрэг эрэлхэг хөвгүүнээрээ бахархсан өдрүүд болов.

Сүхбаатар аймгийн ЗДТГ, Цэргийн штабынхан хошууч генерал Ч.Данзангийн үйл хэргийг мөнхжүүлэх зорилго өвөрлөн хотоос зорин очсон багийн бүрэлдэхүүнийг дотно хүлээн авч хамтарсан арга хэмжээг төв,

орон нутагт зохион байгууллаа. Мөн хошууч генералын ач хүү, бэлтгэл дэд хурандаа Б.Баясгалан, хилийн цэргийн ахмад дайчны хамт Дорнод аймгаас зорин ирж оролцсон юм. “Жаахан шарга” театрт болсон Дурсамж уулзалтад Зэвсэгт хүчин, Онцгой байдал, Цагдаагийн байгууллагын офицер, ахлагч нар, Баруун урт хотын иргэд хөдөлмөрчдийн төлөөлөл оролцов.

Дурсамж уулзалтыг нээж доктор, профессор, бэлтгэл хурандаа Ц.Дэмчигсүрэн нээж “Төрсөн нутаг усныхан, алба хаасан цэрэг армидаа хүндлэгдсэн түүхэн хүн болох хошууч генерал Ч.Данзангийн гавьяаг залуу хойч үеийнхэнд таниулах нь тэдэнд эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх ач холбогдолтой”-г онцлон тэмдэглэсэн. “Нэгдсэн эвлэл” ТББ-аас цэргийн улс төрийн ажилтан Ч.Данзангийн гавьяаг мөнхжүүлэх чиглэлд хийж ирсэн ажлын талаар бэлтгэл хурандаа Б.Жуваа танилцуулж, генерал ач хүү Б.Баясгалан Ч.Данзангийн ажил, амьдралын түүхэн замналыг сонордууллаа.

Эх оронч хөвгүүний үйлсийг



сурталчилж яваа багийн гишүүдээс орон нутгийн телевиз, “Сүхбаатарын өнгө” сонинь сэтгүүлчид ярилцлага авч олны хүртээл болгов. Тэд аймгийн Музейд хошууч генералын эд өлгийн зүйлс, хөрөг зургийг гардуулж цаашид Ч.Данзангийн гавьяаг мөнхжүүлэх чиглэлд хамтарч ажиллахаар тохиролцсон байна. Мөн өдрөө Нэгдсэн эвлэлийн тэргүүн бэлтгэл хурандаа Б.Жуваа, гүйцэтгэх захирал бэлтгэл дэд хурандаа Н.Энхболд, доктор профессор, бэлтгэл хурандаа Ц.Дэмчигсүрэн нар Баруун-Урт хотод сүндэрлэн боссон Соёмбот цогцолбортой танилцаж БХЯ-ны сайд агсан хурандаа генерал Ж.Ёндонгийн хөшөөнд хүндэтгэл үзүүлэв. Дараа нь Зэвсэгт хүчний 338 дугаар ангид зочлон цэрэг дайчидтай уулзалт хийж хошууч генерал Ч.Данзангийн амьдрал, эх оронч үзлийн талаар лекц уншив. ТББ-аас ангийн номын санд ном, хэвлэл дурсгаж, тус ангид байгуулж буй Дайчин алдрын танхимд хошууч генерал Ч.Данзангийн намтар түүхтэй холбоотой булан байгуулах талаар тохиролцов.

Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрмөнх, Цэргийн штабын дарга дэд хурандаа Б.Аваацогт нар цэргийн улс төрийн ахмад ажилтнуудын төлөөллийг

хүлээн авч хамтын ажиллагааны талаар санал солилцов. Энэ үеэр бэлтгэл хурандаа Б.Жуваа орон нутагт Ч.Данзангийн гавьяаг сурталчлах ажлыг эрчимжүүлэх, жил бүр түүний нэрэмжит тэтгэлгийг ҮБХИС-д суралцагч Сүхбаатар аймгийн оюутан, сонсогчид гардуулах, цэргийн анги, дунд сургуулийг нэрэмжит болгох талаар хамтарч ажиллах санал дэвшүүллээ. Аймгийн Засаг дарга хөндсөн саналуудтай холбоотой баримт материалыг ирүүлэхийг хүсэж энэ чиглэлд хамтарч ажиллах хүсэл сонирхолтой байгаагаа илэрхийлсэн байна.

“Нэгдсэн эвлэл” ТББ-ын төлөөлөгчдийг тус аймгийн Сүхбаатар сумын удирдлага хүлээн авч жанжин Д.Сүхбаатарын музейг үзүүлж, тэднийг хөтөчлөн Дархан хан уулын оргилд хүндэтгэл үзүүлснээр орон нутагт зохион байгуулсан “ТББ-ын нэг өдөр” арга хэмжээ амжилттай өндөрлөв. Генерал Ч.Данзангийн гавьяат үйлсийг төрсөн нутагт нь сурталчлахад түүний ач хүү, Монгол Улсын Гавьяат барилгачин Б.Цогт дэмжлэг үзүүлжээ.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 555,233,865

Эдгэрсэн

Нийт: 529,972,043

Нас барсан

Нийт: 6,362,437

Цахим шууданд

“ЭРГЭН ДУРСАХУЙ” ГЭРЭЛ ЗУРАГ, БАРИМТЫН ҮЗЭСГЭЛЭН, НОМЫН БАЯР БОЛЛОО



Тус арга хэмжээний нээлтэд Зэвсэгт хүчний жанжин штабын сургалт бэлтгэлийн газрын дарга, бригадын генерал Г.Болор, дайнд оролцогчдын Монголын хорооны тэргүүн, бэлтгэл хурандаа Г.Лүндэн, ЦБДЭЧ-ын дарга, Соёлын төв өргөөний ерөнхий менежер, хурандаа Г.Золзаяа, Монгол Улсын ардын багш Гантөмөр, Ахмад багш нарын холбооны тэргүүн Монгол Улсын гавьяат багш, профессор, хүндэт доктор, “Багш Эрдэнэ”

Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Монгол Улсын “Хүндэт холбоочин”, Украин Улсын цэргийн холбооны дээд сургуулийн “Хүндэт холбоочин”, “Киев” хотын баатарлаг хамгаалагч Аугаа эх орны болон 1945 оны Чөлөөлөх дайны ахмад дайчин дэд хурандаа Дагвын Тожилсүрэнгийн мэндэлсний 100 насны ойд зориулсан үзэсгэлэн, номын баярыг цэргийн холбоочдын өдрийг тохиолдуулан Монгол цэргийн музейд зохион байгууллаа.

Үзэсгэлэнд ахмад дайчин, дэд хурандаа Д.Тожилсүрэнгийн амьдрал, үйл ажиллагааг өгүүлсэн гэрэл зургийн 12 самбар, түүний гэр бүл, үр хүүхдүүдэд нь хадгалагдаж буй 20 гаруй бүтээл, гэрэл зургийн цомог, одон медаль, баримт бичгүүд болон Монгол цэргийн музейн сан хөмрөгт буй байлдааны туг, үе үеийн дүрэмт хувцас, холбооны техник хэрэгслээс



дээжлэн толилууллаа. Энэхүү арга хэмжээг нээж Монгол цэргийн музейн захирал хурандаа Д.Ганзориг үг хэлсэн бөгөөд хүндэт зочдоор өдгөө 101 насны зооглож буй 1945 оны Чөлөөлөх дайны ахмад дайчин, Монгол Улсын гавьяат холбоочин, дэд хурандаа Т.Бат-Очир хүрэлцэн ирж 1945 оны Чөлөөлөх Дайны түүхэн үйл явдлаас хуваалцлаа.

сэтгүүлийн ерөнхий эрхлэгч Д.Амар, нар болон ахмад дайчин Д.Тожилсүрэнгийн үр хүүхдүүд, ач зээ нар, цэргийн холбоо, улс төрийн ажилтнуудын төлөөлөл зэрэг хүндэт зочид хүрэлцэн ирлээ. Мөн Үзэсгэлэн, номын баярын нээлтийн ажиллагаанд ЦБДЭЧ-ын уран бүтээлчдэд хүрэлцэн ирж уран бүтээлийн дээжээсээ хүргэлээ.

АВТО ЗАМЫН УС ЗАЙЛУУЛАХ ХООЛОЙГ БАРИХ СУРГАЛТ ЯВАГДАНА



атташе, дэд хурандаа Ирики Ёохэй нарын албаныхан хамрагдах бүрэлдэхүүн, сургалтын сэдэв, агуулга, явагдах цаг хугацааг ярилцаж, нэгдсэн ойлголтод хүрсэн юм. Талууд цаашид сургалтын сэдэв, агуулгыг улам баяжуулж, өөр шинэ түвшинд хүргэх талаар ч санал солилцсон юм.

Монгол Улсын Зэвсэгт хүчин, Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчин хамтран “Зам” сургалт, дадлагыг 12 удаа удаагаа зохион байгуулахад бэлэн болжээ.

Сургалт, дадлагын төгсгөлийн шатны төлөвлөлтийн хурал 7 дугаар сарын 4-ний өдөр цахимаар зохион байгуулагдаж, Монгол Улсын талаас Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн Инженерийн дарга, дэд хурандаа Г.Мөнхбат, инженерийн хангалтын офицер, хошууч Б.Батсуурь, гадаад харилцааны офицер, хошууч Б.Лхагвадорж, Япон Улсын талаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Батлан хамгаалахын атташе, дэд хурандаа Ирики Ёохэй нарын албаныхан хамрагдах бүрэлдэхүүн, сургалтын сэдэв, агуулга, явагдах цаг хугацааг ярилцаж, нэгдсэн ойлголтод хүрсэн юм. Талууд цаашид сургалтын сэдэв, агуулгыг улам баяжуулж, өөр шинэ түвшинд хүргэх талаар ч санал солилцсон юм.



Монгол Улсын Зэвсэгт хүчин, Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчин хамтран “Зам” сургалт, дадлагыг 12 удаа удаагаа зохион байгуулахад бэлэн болжээ.

Сургалт, дадлагын төгсгөлийн шатны төлөвлөлтийн хурал 7 дугаар сарын 4-ний өдөр цахимаар зохион

байгуулагдаж, Монгол Улсын талаас Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн Инженерийн дарга, дэд хурандаа Г.Мөнхбат, инженерийн хангалтын офицер, хошууч Б.Батсуурь, гадаад харилцааны офицер, хошууч Б.Лхагвадорж, Япон Улсын талаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Батлан хамгаалахын

УСЧИН ДАЙЧДАД ЧИГЛЭСЭН СУРГАЛТ АМЖИЛТТАЙ ЯВАГДАЖ ӨНДӨРЛӨВ

Зэвсэгт хүчний 234 дүгээр анги

Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 234 дугаар ангийн усчин дайчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх хүрээнд онол, дадлага хосолбор хэлбэрээр хоёр төрлийн сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Нэгдүгээрт, “Сэлэлт болон аврах ажиллагаа” сэдвийн хүрээнд 6 дугаар сарын 6-19-ний өдрүүдэд Зэвсэгт хүчний 014, 016, 123, 234, 186, 327 дугаар нэгтгэл, ангиудын 40 гаруй цэргийн алба хаагч гол мөрнийг түшиглэсэн дадлага голлосон сургалтад хамрагдав. Тэд “Гүүр, ус гатлалтын ерөнхий ойлголт, гүүр тавих, барих техник хэрэгсэл”, “Нэг олсон гүүрийн гаталгаа”, “Байлдааны үед эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх”, “Усанд живсэн хүнд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх”, “Урсгал усанд аврах ажиллагаа”, “Гол мөрөн дээрх аврах ажиллагаа”, “Амьд гарах арга ухаан” зэрэг 10 гаруй сэдвийн хүрээнд мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагаа нэмэгдүүлж чадсан юм.

Хоёрдугаарт, дээрх ангиудын алба хаагчдад Орхон аймгийн “Хангарьд” спорт цогцолбор дахь усан бассейнд түшиглэсэн сургалтыг 6 дугаар сарын 20-24-ний өдрүүдэд зохион байгуулав. Энэхүү сургалтаар анхлан суралцагч нарт усан бассейнд зөв сэлэх, ахисан шатны суралцагч нарт өндрөөс үсэрч, гүнд шумбах, аврах ажиллагааг хэрхэн



зохион байгуулах талаар заасан юм.

Сургалтын хаалтын арга хэмжээ өнгөрсөн 6 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулагдаж, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга, хурандаа Д.Өлзийбаяр, тус

командлалын Цэргийн сургалт, соёл хүмүүжлийн хэлтсийн ахлах офицер, дэд хурандаа Б.Адъяа, Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн захирагч, хурандаа Г.Эрдэнэбаяр нарын албаныхан оролцож, усчин дайчдад баяр хүргэж, амжилт хүслээ.

Ч.ОЮУНЧИМЭГ

“ЭРДЭНЭТИЙН ЦЭРГИЙН ХҮРЭЭ”-НИЙХЭН ЦЭРГИЙН ЁСЛОЛЫН ЖАГСААЛААР АЛХАНА



Зэвсэгт хүчний 186 дугаар анги

Тулгар төрийн 2230, 2231, Их Монгол Улсын 815, 816, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, 111, Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, “Монгол Улсын Төрийн далбааны өдөр”-ийг тохиолдуулан “Эрдэнэт цэргийн хүрээ”-ний төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчид цэргийн ёслолын жагсаалаар алхахаар бэлтгэл ажлаа хангаж байна. Тус цэргийн ёслолын жагсаалд оролцох Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн бүрэлдэхүүн өдөрт 3 цагийн хугацаагаар бэлтгэлээ чамбайруулж, эгнээний болон салбарын жигдрэлтийг хангахад анхаарч байна.

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас Зэвсэгт хүчний нэгтгэл,

ангиудад алба хааж байгаа цэргийн гэрээт болон хугацаат цэргийн албаны байлдагч, түрүүч нарын дунд “Монгол Улсын төлөө зүтгээ” сэдэвт гар зургийн уралдааныг зарлаад байгаа билээ. Энэхүү уралдаанд тус ангиас оролцох байлдагч, түрүүч нарын бүтээлүүдийг шалгаруулахад тэргүүн байрт байлдагч Б.Балжинням, Н.Бунарар, Б.Өлзийжамц, Б.Төгс-Эрдэнэ нарын зурсан зураг шалгарч, Хуурай замын цэргийн

командлалын уралдаан дүгнэх комисст хүргүүлжээ.

Мөн алба хаагчдыг спортоор хичээллэх сонирхлыг нь нэмэгдүүлэх, гар нийлэмжтэй хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор “Сагсанбөмбөг”-ийн тэмцээн зохион байгуулахад ахмад Х.Анхбаяр, ахлах дэслэгч Э.Бат-Эрдэнэ, ахмад М.Уламбадрах ахлагчтай баг тамирчид тэргүүлж, өргөмжлөл, мөнгөн шагналын эзэд болов.

Хошууч О.ОТГОНЦЭЦЭГ



Дарга, ерөнхий редактор, хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ**

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
“Соёмбо” сонин
“Дуулга” студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)